

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн
2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн
санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ГСА-2023/01/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Чойр хот

2023 он

Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа

Утас: 7054-3179

Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Наранбаяр

Утас: 7054-3179

Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Дарханбат

Утас: 7054-3179

Цахим хаяг: Darkhanbatb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга
- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан
- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АЗДНС	Аймгийн Засаг даргын нөөц сан
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ГСА	Говьсүмбэр аймаг
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлэх сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЭМТ	Эрүүл мэндийн төв



АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН
ЗАХИРАГЧ Г.БАТСУУРЬ ТАНАА

**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: govisumber@audit.gov.mn

2023. 04. 20 № 53

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг баримталсан байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

008020230

Бусад асуудлын хэсэг

Аймгийн Засаг дарга нь эрхэм зорилгоо оновчтой бодлого, зохицуулалтаар хангах замаар аймгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх гэж тодорхойлжээ.

Аймгийн ИТХ-ын 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 08 дугаар тогтоолоор ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн чанарын болон тоон үзүүлэлтийг үндэслэн 17 байгууллагын 21 хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж ажилласан байна.

ТЕЗ-ийн хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээгээр 97.1%-ийн хэрэгжилттэй гэж дүгнэжээ.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн нэгтгэсэн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		14,782,119.4	11,667,836.8
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	7,585,575.3	4,730,129.4
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	4а, 4б	0.0	0.0
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	1,943,807.1	1,620,855.2
34	УРЬДЧИЛГАА	7а, 7б	37,785.3	78,892.8
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	5,003,879.0	3,252,993.3
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	88,833.8	64,663.5
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10	122,238.9	1,920,302.5
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		49,388,939.1	30,568,522.2
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	11а, 11б	0.0	0.0
37100	Урт хугацаат хадгаламж		0.0	0.0
37200	Үнэт цаас		0.0	0.0
37300	Урт хугацаат зээл		0.0	0.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	49,388,939.1	30,568,522.2
39100	Газар		0.0	0.0
39200	Биет хөрөнгө		42,598,425.0	26,194,433.7
39300	Биет бус хөрөнгө	13	6,790,514.1	4,374,088.5
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	14	0.0	0.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		64,171,058.4	42,236,359.0
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		14,438,661.8	13,302,822.5
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	2,395,671.9	816,001.4
41100	Богино хугацаат үнэт цаас		0.0	0.0
41200	Богино хугацаат зээлийн өглөг	16а, 16б	0.0	0.0
41300	Өглөг	17а, 17б	2,395,671.9	814,949.5
41400	Урьдчилж орсон орлого	18а, 18б	0.0	1,052.0
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		12,042,989.9	12,486,821.1
42100	Урт хугацаат үнэт цаас	19	0.0	0.0
42200	Урт хугацаат зээл	20а, 20б	12,042,989.9	12,486,821.1
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		49,732,396.6	28,933,536.5
51	Засгийн газрын хувь оролцоо		49,732,396.6	28,933,536.5
51100	Засгийн газрын оруулсан капитал		26,343,617.0	16,822,870.6
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		26,343,617.0	16,822,870.6
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/		0.0	0.0
51102	Өмч /хувийн/ /ТӨҮГ/		0.0	0.0
51103	Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/		0.0	0.0
51104	Халаасны хувьцаа /ТӨҮГ/		0.0	0.0
51105	Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/		0.0	0.0
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/		0.0	0.0
51200	Хуримтлагдсан үр дүн		10,955,103.3	5,810,513.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		12,433,676.2	6,300,152.4
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		0.0	0.0
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга		0.0	0.0
51600	Нөөцийн сан		0.0	0.0
52	Хяналтын бус хувь оролцоо		0.0	0.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		64,171,058.4	42,236,359.0

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		32,925,669.8	21,587,053.7
11	ТАТВАРЫН ОРЛОГО		8,789,885.7	8,527,496.8
110	Орлогын албан татвар		5,483,444.2	6,191,780.5
1100	Хувь хүний орлогын албан татвар		5,657,849.3	6,295,632.6
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-174,405.1	-263,852.1
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч		0.0	0.0
1103	ААН-ын орлогын албан татвар		0.0	160,000.0
1104	Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар		0.0	0.0
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого		0.0	0.0
113	Хөрөнгийн албан татвар		736,868.2	769,295.3
114	Нэмэгдсэн өртгийн албан татвар		0.0	0.0
115	Онцгой албан татвар		0.0	0.0
116	Тусгай зориулалтын орлого		0.0	0.0
117	Гадаад үйл ажиллагааны орлого		0.0	0.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж		2,569,573.3	1,566,421.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1a, 16	18,064,367.4	7,838,301.7
120	Нийтлэг татварын бус орлого		5,853,731.0	3,256,696.5
121	Хөрөнгийн орлого		0.0	0.0
122	Тусламжийн орлого		0.0	0.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		12,210,636.4	4,581,605.2
124	Зээлийн орлого		0.0	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		6,071,416.7	5,221,255.3
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2a, 26	25,418,901.7	19,035,640.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ		25,217,448.2	19,035,640.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		24,505,055.2	15,068,618.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		10,598,175.0	2,871,758.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		1,426,478.7	351,888.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		1,468,457.8	426,886.1
2104	Хангамж, бараа материалын зардал		2,598,388.6	4,317,132.5
2105	Нормативт зардал		1,304,621.2	247,606.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		162,049.9	237,109.5
2107	Томилголт, зочны зардал		62,211.0	65,071.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		2,616,092.3	3,530,742.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		4,268,580.8	3,020,423.2
211	ХҮҮ		0.0	0.0
212	ТАТААС		152,983.7	1,162.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		559,409.3	3,965,859.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		201,453.5	0.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		7,506,768.1	2,551,413.0
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		2,503.0	0.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		4,278,825.9	22,978,705.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		3,230,445.2	-20,427,292.0

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	46,622,689.3	0.0	46,622,689.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-158,218.9	0.0	-158,218.9
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	46,464,470.4	0.0	46,464,470.4
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	38,026.0	0.0	38,026.0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-2,520.0	0.0	-2,520.0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
7	Өмчид гарсан өөрчилөлт	1,975.0	0.0	1,975.0
8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	3,230,445.2	0.0	3,230,445.2
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	49,732,396.6	0.0	49,732,396.6
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	49,732,396.6	0.0	49,732,396.6
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-11,455,617.7	0.0	-11,455,617.7
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	38,276,778.9	0.0	38,276,778.9
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	38,105.8	0.0	38,105.8
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	2,025.0	0.0	2,025.0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0	0.0
18	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	-20,427,292.0	0.0	-20,427,292.0
20	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	28,933,536.5	0.0	28,933,536.5

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)		32,659,391.1	23,673,631.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО		8,789,885.7	8,527,496.8
110	Орлогын албан татвар		5,483,444.2	6,191,780.5
1100	Хувь хүний орлогын албан татвар		5,657,849.3	6,295,632.6
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-174,405.1	-263,852.1
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч		0.0	0.0
1103	ААН-ын орлогын албан татвар		0.0	160,000.0
1104	Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар		0.0	0.0
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого		0.0	0.0
113	Хөрөнгийн албан татвар		736,868.2	769,295.3
114	Нэмэгдсэн өртгийн албан татвар		0.0	0.0
115	Онцгой албан татвар		0.0	0.0
116	Тусгай зориулалтын орлого		0.0	0.0
117	Гадаад үйл ажиллагааны орлого		0.0	0.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж		2,569,573.3	1,566,421.0
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж		420,621.1	275,098.3
1181	Газрын төлбөр		1,460,983.9	924,150.8
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр		687,968.3	367,171.8
1183	Бусад татвар		0.0	0.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		18,360,155.2	9,988,239.2
120	Нийтлэг татварын бус орлого		6,149,518.8	5,406,634.0
121	Хөрөнгийн орлого		0.0	0.0
122	Тусламжийн орлого		0.0	0.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		12,210,636.4	4,581,605.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		5,509,350.2	5,157,895.4
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		22,638,333.1	16,879,281.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ		22,638,333.1	16,879,281.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		21,854,281.7	16,221,139.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		11,521,057.2	4,680,056.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		1,727,163.5	733,904.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		1,765,240.7	3,415,262.7
2104	Хангамж, бараа материалын зардал		1,495,295.4	1,571,381.3
2105	Нормативт зардал		412,434.6	77,482.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		264,543.8	244,443.9
2107	Томилолт, зочны зардал		65,476.2	63,929.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		2,024,298.9	1,720,757.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		2,578,771.4	3,713,921.9
211	ХҮҮ		0.0	0.0
212	ТАТААС		152,983.7	1,162.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		631,067.6	656,979.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		10,021,058.0	6,794,350.1
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)		0.0	0.0

V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		5,413,859.4	9,153,311.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		5,413,859.4	9,153,311.0
2200	Дотоод эх үүсвэрээр		5,413,859.4	9,153,311.0
2260	Гадаад эх үүсвэрээр		0.0	0.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		-5,413,859.4	-9,153,311.0
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		-76,270.0	-496,485.0
14	Бусад эх үүсвэр		0.0	0.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ		76,270.0	496,485.0
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР		0.0	0.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		0.0	0.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		4,530,928.6	-2,855,445.9
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		3,054,646.7	7,585,575.3
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		7,585,575.3	4,730,129.4

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	19,254,006.9	16,347,491.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,676,082.0	10,452,536.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,734,964.6	9,832,112.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,080,074.7	2,864,178.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	347,882.5	304,330.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,210,555.8	3,035,721.3
2104	Хангамж, бараа материалын зардал	239,725.0	212,819.4
2105	Нормативт зардал	15,744.0	9,284.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	300,807.5	288,811.0
2107	Томилолт, зочны зардал	71,833.4	61,405.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	968,833.8	900,184.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,499,507.9	2,155,377.9
212	ТАТААС	2,350.0	1,162.0
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	2,350.0	1,162.0
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	938,767.4	619,262.7
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	630,698.7	335,733.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	308,068.7	283,529.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,027,712.9	5,398,469.4
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	550,212.0	496,485.1
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	19,254,006.9	16,446,231.4
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,205,090.2	3,205,090.2
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	15,043,329.3	12,897,821.2
33	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,005,587.4	343,320.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		858,098.1
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		956,838.3
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	0.4	0.4
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	0.0	0.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	0.2	0.2
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	0.2	0.2

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Тайлан оны гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	342,386.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	342,386.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	228,307.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	14,930.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,866.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,455.0
2103	Хангамж, бараа материалын зардал	6,298.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,061.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	163,689.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,005.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	114,079.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	40,000.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	74,079.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	341,572.4
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	341,572.4
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	86.4
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	813.6

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Аймгийн Засаг дарга нь эрхэм зорилгоо оновчтой бодлого, зохицуулалтаар хангах замаар аймгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх гэж тодорхойлжээ.

Аймгийн ИТХ-ын 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 08 дугаар тогтоолоор ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн чанарын болон тоон үзүүлэлтийг үндэслэн 17 байгууллагын 21 хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж ажилласан байна.

ТЕЗ-ийн хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээгээр 97.1%-ийн хэрэгжилттэй гэж дүгнэсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

1. Төрийн хэмнэлтийн тухай хууль
2. Хөдөлмөрийн тухай
3. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
4. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
5. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль
6. Соёлын тухай хууль
7. Боловсролын тухай хууль /өөрчлөлт/

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говьсүмбэр аймгийн ТЕЗ-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2018 оны А/167 дугаар тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөж байна. Тухайн үед мөрдөгдөж байсан хууль тогтоомж өөрчлөгдсөнтэй холбоотой шинэчлэн боловсруулах шаардлагатай байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 21,934.7 сая төгрөгөөр буюу 34.18 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	7,585.6	4,730.1	-2,855.4
Авлага	1,943.8	1,620.9	-323.0
Урьдчилгаа	37.8	78.9	41.1
Бараа материал	5,003.9	3,253.0	-1,750.9
Нөөцийн бараа	88.8	64.7	-24.2
Бусад эргэлтийн хөрөнгө	122.2	1,920.3	1,798.1
Үндсэн хөрөнгө	49,388.9	30,568.5	-18,820.4
Нийт хөрөнгө	64,171.1	42,236.4	-21,934.7
Өр төлбөр	14,438.7	13,302.8	-1,135.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	49,732.4	28,933.5	-20,803.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	64,171.1	42,236.4	-21,934.7

Хүснэгтээс харахад, мөнгөн хөрөнгө, бараа материал, бусад эргэлтийн хөрөнгө, үндсэн хөрөнгө дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 4,730.1 сая төгрөг болж, өмнөх оноос 2,855.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	0.9	3.7	2.8
Банканд байгаа бэлэн мөнгө	7,584.7	4,726.5	-2,858.3
Төгрөг	7,584.7	4,726.5	-2,858.3
Төрийн сангийн харилцах	7,363.7	4,157.4	-3,206.3
Арилжааны банк дахь харилцах	120.7	478.0	357.3
Бусад төсөл, нөөцийн харилцах	99.5	91.1	-8.4
Нэмэлт санхүүжилтийн харилцах	0.8	-	-0.8
Гадаад валют			
Арилжааны банк дахь харилцах			
Замд яваа мөнгөн хөрөнгө			
Дүн	7,585.6	4,730.1	-2,855.4

Эх сурвалж: (Аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, дансны хууль)

Кассад байгаа бэлэн мөнгө нь “Талын илч” ОНӨААТҮГ-ын 0.5 сая, “Ус-Ду” ОНӨААТҮГ-ын 3.2 сая төгрөгийн үлдэгдэл байна.

Банканд байгаа бэлэн мөнгө нь Төрийн сангийн харилцах 4,157.4 сая, арилжааны банкны харилцах 478.0 сая, бусад нөөцийн харилцах 91.1 сая төгрөгийн үлдэгдлээс бүрдэж байна.

- **Төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл 4,157.4 сая төгрөгийг задалбал:**
 - **Баянтал сум:** Сум хөгжүүлэх сан-20.6 сая, орон нутгийн ерөнхий орлого-12.1 сая, ОНХС-97.8 сая
 - **Сүмбэр сум:** Барьцаа данс-56.8 сая, сум хөгжүүлэх сан-123.1 сая, орон нутгийн ерөнхий орлого-533.1 сая, ОНХС-252.2 сая
 - **Шивээговь сум:** Барьцаа данс-8.2 сая, сум хөгжүүлэх сан-106.0 сая, орон нутгийн ерөнхий орлого-118.9 сая, ОНХС-65.0 сая
 - **Аймаг:** Барьцаа данс-522.9 сая, нэмэлт санхүүжилт данс-73.3 сая, орон нутгийн ерөнхий орлого-1,876.8 сая, ОНХС-290.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.
- **Арилжааны банк дахь харилцах дансны үлдэгдэл 478.0 сая төгрөгийг байгууллагаар нь задалбал:** Ахмадын хороо 1.9 сая, Аймгийн ИТХ-1.6 сая, “Энхтүсдэм” ӨЭМТ-245.3 сая, “Илчлэг шивээ” ОНӨААТҮГ-22.3 сая, “Талын илч” ОНӨААТҮГ-27.0 сая, “Тохижилт сүмбэр” ОНӨААТҮГ-33.3 сая, “Ус-Ду” ОНӨААТҮГ-146.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- **Бусад төсөл, нөөцийн харилцах дансны үлдэгдэл (Ахмадын сан) 91.1 сая төгрөгийг байгууллагаар нь задалбал:**

БОАЖГ-7.1 сая, АЗДТГ-59.6 сая, ОНӨГ-2.8 сая, Сум дундын ойн анги- 2.9 сая, Сүмбэр сумын ЗДТГ-11.9 сая, Шивээговь сумын ЗДТГ-6.5 сая, Шивээговь сумын ИТХ-0.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2,855.4 сая төгрөг буюу 37.64%-иар буурахад өмнөх оны хөрөнгө оруулалтын ажлын барьцаа хөрөнгө 1,293.5 сая төгрөгийг чөлөөлсөн, гүйцэтгэлийн төсвөөр санхүүжихээр болсон боловсрол, соёл, эрүүл мэндийн байгууллагуудын ахмадын сангийн үлдэгдэл 25.6 сая төгрөгийг улсын төсөвт шилжүүлсэн, сум хөгжүүлэх сангаас зээл олголт хийсэнтэй холбоотойгоор сангийн үлдэгдэл 239.6 сая төгрөгөөр буурсан нь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл буурахад гол нөлөө үзүүлжээ.

Аудитын илрүүлэлт:

Мөнгөн хөрөнгийн бүртгэл тайлагналтай холбоотой материаллаг зөрчил илрээгүй.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 1,620.9 сая төгрөг болж, өмнөх оноос 323.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагсадтай холбогдсон авлага	6.7	1.8	- 4.8
Төлбөртэй үйлчилгээний авлага	512.9	9.8	- 503.1
Зээлийн хүүгийн авлага	33.3	29.8	- 3.4
Дансны авлага /ТӨҮГ/	31.6	44.2	12.6
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	3.0	13.0	10.0
Байгууллагаас авах авлага	373.9	794.3	420.4
Хувь хүмүүсээс авах авлага	982.5	727.9	- 254.6
Дүн	1,943.8	1,620.9	- 323.0

/сая төгрөгөөр/

Эх сурвалж: (Аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан)

Нийт авлагын 3.9 хувийг аймаг, сумдын ОНХС, 74.6 хувийг сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага, 4.3 хувийг төсвийн байгууллага, 17.2 хувийг ОНӨААТҮГ-уудын халаалт, цэвэр, бохир ус, үйлчилгээний авлага эзэлж байна.

Авлагын дансны үлдэгдлийг нэр, төрлөөр нь задалбал:

Ажиллагсадтай холбоотой авлага өмнөх оноос 4.8 сая төгрөгөөр буурсан бөгөөд гүйцэтгэлийн үр дүнгээр санхүүжих тогтолцоонд шилжиж улсын төсвөөс санхүүжихээр болсон эрүүл мэнд, боловсрол, соёлын байгууллагуудын авлага-3.2 сая, ОНӨААТҮГ-уудын авлага-1.6 сая төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлжээ.

Төлбөртэй үйлчилгээний авлага Ковид-18 цар тахлын эмчилгээний санхүүжилтийн авлага 501.5 сая төгрөгийг сумдын эрүүл мэндийн төвүүдэд эрүүл мэндийн даатгалын сангаас олгосонтой холбоотой байна.

Зээлийн хүүгийн авлага өмнөх оноос 3.4 сая төгрөгөөр буурсан бөгөөд үүнд Сүмбэр, Шивээговь сумын сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага 10.9 сая төгрөгөөр буурч, 7.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Дансны авлага өмнөх оноос 12.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь "Талын илч" ОНӨААТҮГ-ын айл өрхөөс авах дулааны авлагатай холбоотой байна.

Татвар, НДШ-ийн авлага 10.0 сая төгрөгөөр нэмэгдэхэд "Ус-Ду" ОНӨААТҮГ-9.6 сая, "Талын илч" ОНӨААТҮГ - 0.4 сая төгрөгийн илүү төлөлттэй холбоотой байна.

Байгууллагаас авах авлага өмнөх оноос 420.0 сая төгрөгөөр нэмэгдэхэд Баянтал сумын сум хөгжүүлэх сан-85.0 сая, Сүмбэр сумын сум хөгжүүлэх сан-408.0 сая, Сүмбэр сумын ОНХС-6.8 сая, аймгийн ИТХ-12.5 сая, "Илчлэг шивээ" ОНӨААТҮГ-33.5 сая, "Тохижилт Сүмбэр" ОНӨААТҮГ-17.4 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, "Ус-Ду" ОНӨААТҮГ-94.0 сая, АЗДТГ-19.3 сая, ГХБХБГ-25.2 сая, Номын сан 2.5 сая, Баянтал сумын 4-р цэцэрлэгийн авлага 2.1 сая төгрөгөөр тус тус буурсан нөлөөлжээ.

Аудитын илрүүлэлт:

Авлагын данстай холбоотой 39.5 сая төгрөгийн алдаа илрүүлж, аудитын явцад залруулсан байна. Үүнд:

1. "Тохижилт Сүмбэр" ОНӨААТҮГ нь "Өнгө нэм" НҮТББ-тай байгуулсан хог хаягдлын менежментийн зөвлөх үйлчилгээний гэрээний дагуу урьдчилж шилжүүлсэн 6.0 сая төгрөгийг шууд зардлаар бүртгэж авлага үүсгээгүй, Хог хаягдлын хураамжийн авлагыг 14.1 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн.
2. "Говьсүмбэр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал" нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас төлбөрийг бүрэн шилжүүлсэн боловч ашиглалтад хүлээн аваагүй 11.0 сая төгрөгийн хяналтын камер, 1.5 сая төгрөгийн мэдээллийн самбарыг авлага үүсгэж бүртгээгүй шууд зардлаар тайлагнасан.
3. "Сүмбэр сумын Орон нутгийн хөгжлийн сан" нь СЗДТГ-ын үйл ажиллагаанд ISO стандарт нэвтрүүлэх ажлын хүрээнд урьдчилж шилжүүлсэн 6.0 сая төгрөгийг шууд зардлаар бүртгэж, авлага үүсгээгүй.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 73.9 сая төгрөг болж, өмнөх оноос 41.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	1.9	0	-1.9
Төсөвт байгууллага	15.0	57.6	42.6
Урьдчилгаа тооцоо	20.9	21.3	0.4
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	1.1	1.1	0
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	15.0	20.0	5.0
Цалингийн урьдчилгаа	4.8	0.2	-4.6
Дүн	37.8	78.9	41.1

Эх сурвалж: (Аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан)

Урьдчилгаа данс өмнөх оноос 41.1 сая төгрөгөөр нэмэгдэж, 78.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Урьдчилгаа дансыг задалбал:

1. **Урьдчилж гарсан зардал данс** аймгийн ИТХ-ын 1.9 сая төгрөгөөр буурсан.
2. **Төсөвт байгууллагын урьдчилгаа данс** аймгийн ЗДТГ-ын 15.0 сая төгрөгөөр буурч нэмэлт санхүүжилтийн авлага 57.6 сая төгрөгөөр нэмэгдсэн.
3. **Бараа материалын урьдчилгаа данс** авто замын сангийн бараа материалын бэлтгэх урьдчилгаа 1.1 сая үлдэгдэлтэй.
4. **Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа** дансанд авто замын сангийн өмнөх оны үлдэгдэл 15.0 сая, тайлант онд ОНТХО-ын зураг төсвийн урьдчилгаа 5.0 сая төгрөгөөр нэмэгдэж, 20.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй.
5. **Цалингийн урьдчилгаа** данс нь өмнөх оноос 4.6 сая төгрөгөөр буурч, Баянтал сумын ЗДТГ-ын 0.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

Урьдчилгаа данстай холбоотой 5.0 сая төгрөгийн алдаа илрүүлж, аудитын явцад залруулсан байна. Үүнд:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар "Сүмбэр гарден соёл спорт амралтын хүрээлэнгийн засварын ажлын зураг төсөв хийлгэх ажил"-ын урьдчилгаанд 5.0 сая төгрөгийг "Ориентплюс" ХХК-д шилжүүлсэн боловч шууд зардлаар бүртгэсэн.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 3,253.0 сая төгрөг болж, өмнөх оноос 1,750.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	461.4	272.0	-189.4
Тусгай зориулалттай материал	334.2	151.1	-183.1
Эм боох материал	127.1	120.9	-6.2
Дуусаагүй үйлдвэрлэл	-	-	-
Бэлэн бүтээгдэхүүн	7.8	-	-7.8
Хангамжийн материал	4,139.0	2,609.4	-1,529.6
Бичиг хэргийн материал	65.6	14.0	-51.7
Аж ахуйн материал	1,268.9	438.2	-830.7
Сэлбэг хэрэгсэл	24.0	4.0	-20.0
Түлш, шатах тослох материал	9.8	8.5	-1.4
Барилгын засварын материал	221.9	53.1	-168.7
Хүнсний материал	36.5	-	-36.5
Бусад хангамжийн материал	2,512.3	2,091.6	-420.7
Мал амьтад	395.8	371.6	-24.1
Дүн	5,003.9	3,253.0	-1,750.9

Эх сурвалж: (Аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан)

Бараа материал дансны эхний үлдэгдэл 5,003.9 мянган төгрөг байсан ба тайлант хугацаанд худалдан авсан 1,893.1 сая, үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын орлого 427.4 сая, нийт 2,320.5 сая төгрөгөөр нэмэгдэж, байгууллагын үйл ажиллагаанд 2,364.8 сая төгрөгийг зарцуулж, 8.3 сая төгрөгийг шилжүүлж, гүйцэтгэлийн үр дүнгээр санхүүжих байгууллагуудын 1,571.4 сая төгрөгийн бараа материалыг ТЭЗ хооронд шилжүүлж, бусад (данс хооронд болон акталж устгасан) 126.8 сая төгрөгөөр хасагдаж нийт 4,071.4 сая төгрөгөөр буурч 3,253.0 сая төгрөгийн үлдэгдэл тайлагнасан байна.

Аудитын илрүүлэлт

Бараа материал данстай холбоотой нийт 625.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч 621.8 сая төгрөгийн алдааг залруулж, 3.7 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1 албан шаардлага, 7 зөвлөмж өглөө. Үүнд:

1. Залруулсан нийт алдаа 621.7 сая төгрөг бөгөөд гүйцэтгэлийн үр дүнгээр санхүүжих тогтолцоонд шилжсэн Сүмбэр сумын байгууллагууд бараа материалын үлдэгдлийн дүнгээр хаалтын бичилт хийгээгүй улмаас 428.4 сая, Шивээговь сумын ЗДТГ-183.7 сая, СХДАА-0.6 сая, Насан туршийн боловсролын төв-1.1, Шивээговь сумын ИТХ-2.2 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаанд зарцуулсан боловч үлдэгдлээр тайлагнасан, Сум дунд ойн анги, Илчлэг шивээ ОНӨААТҮГ-ууд 0.6 сая төгрөгийн шатахууны худалдан авалтад ногдох урамшууллыг бүртгээгүй, Баянтал сумын ЗДТГ-5.1 сая төгрөгийн бараа материалыг тодруулга тайланд ангилал зөрүүтэй тайлагнасан тул аудитын явцад залруулсан.
2. Төлбөрийн акт нийт 3.7 сая төгрөг бөгөөд СХДАА-0.1 сая, Шивээговь сумын ЗДТГ-3.6 сая төгрөгийн шатахууны тооцоог жолоочийн тооцооны хуудсанд үндэслэн бодоогүй, тогтоосон нормоос хэтрүүлэн зарцуулсан тул орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 1,920.3 сая төгрөг болж, өмнөх оноос 1,798.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	122.2	1,920.3	1,798.1
Дүн	122.2	1,920.3	1,798.1

Эх сурвалж: (Аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан)

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдлийг байгууллагаар нь задалж үзэхэд БОАЖГ-93.6 сая, Авто замын сан 325.4 сая, аймгийн ОНХС-1,501.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт

Бусад эргэлтийн хөрөнгө данстай холбоотой 2 зөрчил илрүүлж зөвлөмж өгсөн байна. Үүнд:

1. Авто замын сангийн хөрөнгөөр хийгдсэн 325.4 сая төгрөгийн 1 ажил, аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэж ашиглалтад хүлээн авсан 941.2 сая төгрөгийн 13 ажлыг ашиглагч, эзэмшигч байгууллагад бүртгүүлээгүй тул зөвлөмж өгчээ.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 30,568.5 сая төгрөг болж, өмнөх оноос 18,820.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	42,598.4	26,194.4	-16,404.0
Барилга, байгууламж, орон сууц	24,516.7	11,317.1	-13,199.6
Авто-тээврийн хэрэгсэл	1,606.4	1,444.8	-161.7
Машин тоног төхөөрөмж(компьютер)	4,543.3	3,018.5	-1,524.8
Тавилга, аж ахуйн эд хогшил	878.5	316.3	-562.2
Зам, гүүрийн байгууламж	5,568.1	5,332.6	-235.5
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	87.4	-	-87.4
Бусад үндсэн хөрөнгө	5,178.0	4,750.1	-427.9
Дуусаагүй барилга, байгууламж	15.0	15.0	-
Ном	204.9	-	-204.9
Биет бус хөрөнгө	6,790.5	4,374.1	-2,416.4
Программ хангамж	60.2	29.5	-30.7
Бусад биет бус хөрөнгө	6,730.3	4,344.6	-2,385.7
Бусад хөрөнгө /ТӨҮГ/	-	-	-
Хойшлогдсон татварын хөрөнгө /ТӨҮГ/	-	-	-
Бусад эргэлтийн бус хөрөнгө /ТӨҮГ/ + Бусад	-	-	-
Дүн	49,388.9	30,568.5	-18,820.4

Эх сурвалж: (Аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан)

Тайлан хугацаанд үндсэн хөрөнгө данс нь худалдан авсан 177.3 сая, шилжүүлэн авсан 437.7 сая, хөрөнгийн ашиглах жил, өртгийг шинэчлэн тогтоосон болон бусад байгууллагаас хүлээн авсан 1,447.4 сая, нийт 2,062.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайлант хугацаанд данснаас акталж устгасан 1,136.9 сая, шилжүүлсэн 42.1 сая, гүйцэтгэлийн үр дүнгээр санхүүжих боловсрол, соёл, эрүүл мэндийн байгууллагын 21,627.2 сая, дахин үнэлгээний хорогдол 222.9 сая, нийт 23,029.1 сая төгрөгөөр буурсан байна.

Дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй 15.0 сая төгрөг нь "Илчлэг-Шивээ" ОНӨААТҮГ-ын барилгын өргөтгөлийн зураг байна.

Аудитын илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн данстай холбоотой 5,143.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн бөгөөд 308.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, 4,834.9 сая төгрөгийн бүртгэлийн алдааг аудитын явцад залруулсан байна. Үүнд:

1. Залруулсан нийт алдаа 4,834.9 сая төгрөг бөгөөд гүйцэтгэлийн үр дүнгээр санхүүжих тогтолцоонд шилжсэн Сүмбэр сумын байгууллагууд үндсэн хөрөнгийн үлдэгдлийн дүнгээр хаалтын бичилт хийгээгүй улмаас 4,812.0 сая, Насан туршийн боловсролын төв-1.0 сая, Шивээговь сумын ЗДТГ-2.9 сая, Сум дундын ойн анги-5.3 сая, "Илчлэг шивээ" ОНӨААТҮГ-11.9 сая, Шивээговь сумын ИТХ-0.9 сая төгрөгийн хөрөнгийг дансны ангиллын дагуу үнэн зөв бүртгээгүй, Насан туршийн боловсролын төв-0.8 сая төгрөгийн худалдан авсан үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй байсан зөрчлүүдийг илрүүлж аудитын явцад залруулсан.

2. АЗДТГ-ын жилийн эцсийн хөрөнгийн тооллогын хийгээгүй, Шивээговь сумын ОНХС-аар хийгдсэн хөрөнгийг ашиглагч байгууллагад бүртгүүлээгүй зөрчилд 308.0 сая төгрөгийн албан шаардлага өгчээ.

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 13,302.8 сая төгрөг болж, өмнөх оноос 1,135.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Богино хугацаат өр төлбөр дүн	2,395.7	816.0	-1,579.7
Ажилчидтай холбогдсон өглөг	22.5	5.8	-16.7
Бараа үйлчилгээний зардлын өглөг	19.2	8.3	-10.9
Байгууллагад төлөх өглөг	2,221.1	700.0	-1,521.1
Хувь хүмүүст төлөх өглөг	2.2	0.8	-1.4
Татвар, НДШ-ийн өглөг	130.7	100.1	-30.7
Урьдчилж орсон орлого	-	1.1	1.1
Урт хугацаат өр төлбөр дүн	12,043.0	12,486.8	443.8
Хойшлогдсон өр төлбөр /ТӨҮГ/	12,043.0	12,486.8	443.8
Нийт дүн	14,438.7	13,302.8	-1,135.8
Үүнээс, байгууллагын төрлөөр			-
Төсөвт байгууллага	94.4	110.3	15.8
Төсөл, сан	1,866.9	587.9	-1,279.0
ТӨҮГ болон ОНӨҮГ	12,477.3	12,604.7	127.4
ДҮН	14,438.7	13,302.8	-1,135.8

Эх сурвалж: (Аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан)

Нийт богино хугацаат өр төлбөрийн 72.0 хувь буюу 587.9 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын барьцаа дансны өр төлбөр эзэлж байна.

- **Ажиллагсадтай холбоотой өр төлбөр** дансны эхний үлдэгдэл 22.5 сая төгрөг үүнээс Шивээговь сумын ИТХ-2.7 сая, Цөм сүргийн үржлийн төв ОНӨАҮГ-0.5 сая, Сүмбэр сумын ЗДТГ-2.4 сая, Насан туршийн боловсролын төв, СДОА-0.05 сая нийт 5.6 сая төгрөгийн өр төлбөр шинээр бүртгэж, Баянтал сумын ЭМТ-2.6 сая, Шивээговь сумын ЭМТ-17.2 сая, 1-р сургууль-0.3 сая, 5-р сургууль 1.5 сая, 1-р цэцэрлэг-0.06 сая, Шивээговь сумын Соёлын төв-0.07 сая, аймгийн ИТХ-ын 0.05 сая, Шивээговь сумын ЗДТГ-0.6 сая, нийт 22.4 сая төгрөгийн өр төлбөрийг барагдуулж 5.8 сая төгрөгийн үлдэгдэл тайлагнажээ.
- **Бараа үйлчилгээний зардлын өр төлбөр** дансны эхний үлдэгдэл 19.2 сая төгрөг үүнээс шинээр Сүмбэр сумын ЗДТГ-3.2 сая бүртгэж, ЦСҮТ-1.5 сая, Баянтал сумын 4-р цэцэрлэг-2.5 сая, Баянтал сумын ЭМТ-0.3 сая, Шивээговь сумын ЭМТ-9.8 сая, нийт 14.0 сая төгрөгөөр буурч 8.3 сая төгрөгийн үлдэгдэл тайлагнажээ.
- **Байгууллагад төлөх өр төлбөр** дансны эхний үлдэгдэл 2,221.1 сая төгрөг үүнээс АЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн өр-42.6 сая, Барьцаа дансны өр-15.2 сая, Сүмбэр сумын ЗДТГ-3.1 сая, ЦСҮТ ОНӨҮГ-0.1 сая, Шивээговь сумын барьцаа дансны өр-0.2, Шивээговь сумын ЗДТГ-0.1 сая, Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ-4.1 сая нийт 64.1 сая төгрөгөөр нэмэгдэж, Баянтал сумын ЭМТ-0.3 сая, Баянтал сумын ОНХС-1.2 сая, аймгийн Барьцаа дансны өр-1,293.5 сая, аймгийн ИТХ-0.2 сая, Сүмбэр сумын 1-р сургууль 0.7 сая, Боржигин чуулга-0.3 сая, Илчлэг шивээ ОНӨААТҮГ-84.6 сая, Талын илч ОНӨААТҮГ-1.3 сая, Ус-Ду ОНӨААТҮГ-204.0 сая, нийт 1,586.1 сая төгрөгөөр буурч, 700.0 сая төгрөгийн үлдэгдэл тайлагнажээ.
- **Татварын НДШ-ийг өр** дансны эхний үлдэгдэл 130.7 сая төгрөг бөгөөд "Илчлэг Шивээ" ОНӨААТҮГ-ын өр 40.8 сая, "Талын илч" ОНӨААТҮГ-ын өр 8.1 сая, нийт 48.9 сая төгрөгөөр нэмэгдэж "Илчлэг Шивээ" ОНӨААТҮГ-ын НДШ-ийн өр-79.5 сая төгрөгөөр буурсан нь нөлөөлжээ.
- **Хойшлогдсон өр төлбөр** дансны эхний үлдэгдэл 12,043.0 сая төгрөг бөгөөд "Илчлэг шивээ" ОНӨААТҮГ-137.2 сая, "Талын илч" ОНӨААТҮГ-70.7 сая, "Тохижилт Сүмбэр" ОНӨААТҮГ-438.9 сая, нийт 646.8 сая төгрөгийн хойшлогдсон өр төлбөр нэмэгдэж, "Ус-Ду" ОНӨААТҮГ-203.0 сая төгрөгөөр бууруулж, 12,486.8 сая төгрөгийн үлдэгдэл тайлагнасан байна.

Аудитын илрүүлэлт:

Өр төлбөр холбоотой 42.9 сая төгрөгийн алдаа илрүүлж, аудитын явцад залруулсан байна.

Үүнд:

1. Сүмбэр сумын ЗДТГ-3.3 сая төгрөгийн өр төлбөртэй гарсан боловч "Тохижилт Сүмбэр" ОНӨААТҮГ-аар төлүүлсэн, Баянтал сумын ЗДТГ нь 13.6, ИТХ-0.3 сая сая төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, "Тохижилт Сүмбэр" ОНӨААТҮГ өр төлбөргүй боловч Сүмбэр сумын ЗДТГ-ын 3.3 сая өр төлбөрийг төлсөн, Шивээговь сумын ЗДТГ-14.9 сая төгрөгийн өр төлбөрийг барагдуулсан боловч НББ-д тайлагнаагүй, "Илчлэг Шивээ" ОНӨААТҮГ-7.5 сая төгрөгийн ХХОАТ, НӨАТ-ийг илүү дутуу тайлагнасан.

3.4.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 28,933.5 сая төгрөг болж, өмнөх оноос 20,798.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	49,732.4	28,933.5	-20,798.9
Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	26,343.6	16,822.9	-9,520.75
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	-	-	-
Хуримтлагдсан үр дүн	10,955.1	5,810.5	-5,144.6
Өмнөх үеийн үр дүн	7,724.7	26,237.8	18,513.15
Тайлант үеийн үр дүн	3,230.4	- 20,427.3	-23,657.74
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	12,433.7	6,300.2	-6,133.52
Дүн	49,732.4	28,933.5	-20,798.9

Эх сурвалж: (Аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан)

Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө данс нь гүйцэтгэлийн үр дүнгээр санхүүжих тогтолцоонд шилжсэн 4-р сургууль 448.0 сая, 4-р цэцэрлэг-59.2 сая, Баянтал сумын Соёлын төв-130.5 сая, Баянтал сумын ЭМТ-523.4 сая, ГХБХБГ-86.9 сая, Боржигин өв музей-18.8 сая, Номын сан-61.3 сая, ГБХЗХГ-83.5 сая, БТСГ-2,475.6 сая, 1-р сургууль-631.6 сая, 1-р цэцэрлэг-109.4 сая, 2-р сургууль 1,039.0 сая, 2-р цэцэрлэг-169.9 сая, 5-р сургууль-1,431.1 сая, 5-р цэцэрлэг-670.7 сая, 6-р цэцэрлэг-21.9 сая, Боржигин чуулга-479.0 сая, 3-р сургууль-440.8 сая, 3-р цэцэрлэг-331.7 сая, Шивээговь сумын соёлын төв-46.4 сая, Шивээговь сумын ЭМТ-263.9 сая нийт 9,522.7 сая төгрөгөөр буурч ЦСҮТ ОНӨҮГ-2.0 сая төгрөгөөр нэмэгдэж 9,520.7 сая төгрөгийн үлдэгдэл тайлагнасан байна.

Хуримтлагдсан үр дүн данс 5,144.6 сая төгрөгөөр буурч 5,810.5 сая төгрөгийг тайлагнасан нь гүйцэтгэлийн үр дүнгээр санхүүжих байгууллагуудын хөрөнгө, бараа материалыг тайлант үеийн зардлаар бүртгэсэнээс шалтгаалсан байна.

Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү данс нь 6,133.5 сая төгрөгөөр буурч 6,300.2 сая төгрөгийн үлдэгдэл тайлагнасан нь гүйцэтгэлийн үр дүнгээр санхүүжих байгууллагуудын үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний зөрүүг шилжүүлсэнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Аймгийн ТЕЗ-ийн 2022 оны төсвийг Сангийн яамнаас анх батлахдаа татварын орлогыг 6,335.0 сая, татварын бус орлогыг 691.6 сая, улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг 2,277.4 сая, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг 3,494.5 сая, нийт 12,798.5 сая төгрөгөөр, суурь зарлагыг 9,304.0 сая, ОНХС-гийн зардал 3,494.5 сая, нийт 12,798.5 төгрөгөөр баталсан байна.

Аймгийн СТСХ-ээс төсвийн суурь орлогыг 618.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 7,644.9 сая, бусад эх үүсвэрээс буюу 2021 оны давсан орлого 1,500.0 сая, зардлын хэмнэлт 438.5 сая, эхний үлдэгдэл 591.7 сая, улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг 2,277.0 сая, ОНХНС-гаас олгох шилжүүлэг 3,494.5 сая, нийт 15,946.6 сая төгрөгийн эх үүсвэр төлөвлөсөн.

Суурь зарлагыг 1,276.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 10,580.9 сая, ОНХС-гийн 2021 оны дансны үлдэгдэл 72.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 3,566.5 сая, ОНХО-1,799.2 сая, нийт 15,946.6 сая төгрөгийн зардал төлөвлөж, төсвийн төслийг боловсруулан аймгийн ИТХ-д өргөн барьсан байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 17,427.4 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны төсвийг тодотголоор 1,826.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж 19,254.0 сая төгрөг болгон баталжээ. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 22 хөтөлбөрийг санхүүжүүлэхээр 3,205.1 сая төгрөгийг ОНХНС-гаас, 1,376.5 сая төгрөгийг улсын төсвөөс, 13,666.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 209.1 сая төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоос, 796.5 сая төгрөгийг өмнөх оны үлдэгдлээс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 1,376.5 сая, ОНХНС-гийн орлогын шилжүүлэг 3,205.1 сая, Орон нутгийн төсвөөс 11,521.3 сая, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 343.3 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 16,347.5 сая төгрөг буюу 85 хувьтай байгаа нь бараа ажил үйлчилгээний зардал-902.8 сая, төрийн өмчит байгууллагад олгох татаас-1.2 сая, урсгал шилжүүлгийн зардлыг 319.5 сая, хөрөнгийн зардлыг 1,629.2 сая, эргэн төлөгдөх зээл 53.7 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	70105 ОН-ын өөрөө удирд ёсны байгууллага	1,029.1	1,002.2	26.9	97%
2	70106 ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага	4,817.1	4,327.9	489.1	90%
3	70417 Мэргэжлийн хяналт	122.8	102.3	20.4	83%
4	70426 Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүл	155.3	119.1	36.1	77%
5	70503 Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт	7,685.6	5,738.8	1,946.8	75%
6	70801 Мал аж ахуйг хөгжүүлэх	178.8	156.1	22.7	87%
7	71101 Авто зам	493.2	442.7	50.5	90%
8	71105 Авто тээврийн хяналт, зохицуулалт	2.4	1.2	1.2	49%
9	71403 Ойжуулалт	146.8	133.2	13.6	91%
10	71411 Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	394.6	344.7	49.9	87%
11	71506 Суурин газрын усан хангамж	36.9	36.9	0.0	100%
12	71508 Гудамжны гэрэлтүүлэг	8.3	-	8.3	0%
13	71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ	198.6	164.3	34.3	83%
14	71701 Биеийн тамир спорт	290.5	289.5	1.0	100%
15	71702 Соёл урлаг	181.4	177.5	3.9	98%
16	71801 Сургуулийн өмнөх боловсрол	556.0	506.6	49.5	91%
17	71802 Ерөнхий боловсрол	1,521.4	1,440.9	80.5	95%
18	71804 Мэргэжлийн боловсрол	715.7	715.7	0.0	100%
19	71806 Насан туршийн болон албан бус боловсрол	78.1	77.9	0.2	100%
20	71902 Нийгмийн халамж	38.5	20.5	18.0	53%
21	72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	550.2	496.5	53.7	90%
22	72208 Ахмад настны хөгжил хамгаалал	52.9	52.9	-	100%
Нийт		19,254.0	16,347.5	2,906.5	83%

Эх сурвалж: (Аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан)

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар дээд шатны төсвийн захирагчаас 258.2 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 84.2 сая, нийт 342.4 сая төгрөгийн орлогыг бүртгэж тайлагнасан байна.

Үүнээс цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардалд 14.9 сая, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардалд 1.9 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 5.4 сая, хангамж, бараа материалын зардалд 6.3 сая, эд хогшил, урсгал засварын зардалд 13.1 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 163.7 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 23.0 сая, бусад урсгал шилжүүлгийн зардалд 40.0 сая, нийт 268.3 сая төгрөгийг зарцуулжээ.

Санхүүгийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд нэмэлт санхүүжилтийн дансны 24.4 сая төгрөгийн орлого, байгууллагуудын зардлын давхардсан гүйлгээг устгасан байна.

Аймаг, сумдын нэмэлт төвлөрүүлэлтийн дансны эхний үлдэгдэл 0.8 сая төгрөг байсан тайлант хугацаанд үлдэгдэл тайлагнаагүй байна. АЗДТГ-ын төвлөрүүлсэн 74.1 сая төгрөгөөс 57.6 сая төгрөгийг урьдчилгаа дансанд бүртгэж 16.5 сая төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогод төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Аймгийн ИТХ-ын 2022 оны 08-р тогтоолоор ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн, чанарын болон тоон шалгуур үзүүлэлтийг баталсан. Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 22 хөтөлбөрт 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 11. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/сая төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	Аймгийн ИТХ-ын үйл ажиллагаа,	2022	МУЗЗНДНТУТХ болон Төсвийн тухай хуульд заасан чиг үүргийг цаг хугацаанд нь хэрэгжүүлэх	100%	509.9	483.8
2	ГХУСАХ	2022	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулж, гэмт хэргийн гаралтыг бууруулна	100%	205.7	204.7
3	Засаг даргын ажлын алба	2022	Оновчтой бодлого, зохицуулалтаар хангах замаар аймгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх	100%	1,566.3	1,390.4
4	Засаг даргын нөөц	2022	Сангийн сайдын тушаалаар батлагдсан аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийг захиран зарцуулах журам хэрэгжсэн байна.	100%	409.7	318.9
5	Засаг даргын хэрэгжүүлэх арга хэмжээний зардал	2022	Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэх 19 арга хэмжээг үр дүнтэй, чанартай зохион байгуулсан байна.	100%	623.0	471.7
6	Нийтийн тээврийн хөнгөлөлт	2022	Аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан нийтийн тээврийн үйлчилгээг үнэ төлбөргүй болон хөнгөлөлттэй үнээр хүртсэн байна.	100%	2.3	1.1
7	Авто замын сан	2022	Орон нутгийн авто замын чанар, нөхцөл сайжирна.	93.4%	493.2	460.5
8	Ахмадын хороо	2022	Ахмад настны нийг-мийн халамж, хамгааллыг сайжруулах, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг	100%	52.9	52.9

			сайжруулах, ахмадуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэнэ.			
9	Орон нутгийн өмчийн газар	2022	Орон нутгийн өмч, хөрөнгийн үр ашиг сайжирсан байна, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангуулсан байна.	100%	155.2	155.2
10	Байгаль орчин аялал, жуулчлалын газар	2022	Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлийн багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах.	100%	165.6	152.9
11	Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээ	2022	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн зорилт хангагдсан байна.	82.9%	229.0	189.7
12	Цөм сүргийн үржлийн төв	2022	Сүмбэр үүлдрийн хонины удмын санг хамгаалж, тоо толгойг өсгөж, каракуль хурганы арьсны чанарыг сайжруулан борлуулж төсвийн орлогын биелэлтийг хангуулна.	90%	148.8	127.7
13	Нийгмийн Халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт тусламж	2022	Нийгмийн хамгааллын бодлогыг зорилтот бүлэгт чиглүүлэх	100%	38.5	20.5
14	Санхүүгийн хяналт аудитын алба	2022	Санхүүгийн сахилга батыг сайжруулж, төсвийн байгууллагад нийтлэг илэрч буй зөрчлийг 2019 оны үзүүлэлтээс 10 хувь хүртэл бууруулах, мэргэжил арга зүйн зөвлөгөөг тогтмол өгөх 2, Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг сайжруулж 90%-д хүргэх	100%	122.7	102.3
15	Сум дундын ойн анги	2022	Ойн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, ногоон байгууламжийг хамгаалах, тогтвортой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.	100%	146.7	97.6
16	Насан туршийн боловсролын төв	2022	Насан туршийн боловсролын үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллах	100%	78.1	77.9
17	Биеийн тамир спортын газар, Усан спорт сургалтын төвийн үйл ажиллагааны зардал	2022	Иргэдийн биеийн тамир, усан спортоор хичээллэх, бие бялдраа чийрэгжүүлэх, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлэн хэвийн үйл ажиллагааг хангана.	100%	290.4	289.5
18	Орон нутгийн өмчийн арчилгаа, хамгаалалт, засвар, үйлчилгээний төлбөр	2022	Хууль, журамд нийцүүлэн байр ашиглалтын үйлчилгээг зохион байгуулсан байна.	100%	821.7	821.4
19	Мал эмнэлгийн вакцин	2022	Мал, амьтныг Зохио норм, хугацаанд вакцинд хамруулах	100%	7.9	7.9
20	Орон нутгийн хөгжлийн сан	2022	Хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг хууль, журмын дагуу төлөвлөн хэрэгжилтийг хангах ажиллах	92%	1,838.1	1,548.0
21	Орон нутгийн хөрөнгө оруулалт	2022	Хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг хууль, журмын дагуу төлөвлөн хэрэгжилтийг хангах ажиллах	88.9%	3,587.8	2,411.0
Нийт				97.1%	11,493.5	9,385.6

Эх сурвалж: (Аймгийн Засаг даргын Тамгын ХШҮХ-ийн тайлан)

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Говьсүмбэр аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах орлого бүрдүүлэлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Дарханбат гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр, Дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Говьсүмбэр аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/301 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 50,603.9 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 759.0 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн

4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор дараах арга хэмжээ авч ажилласан байна.

Энэ хуулийн хүрээнд тэвчиж болох эд хогшлын зардлыг-11.9 сая, дотоод албан томилолтын зардлыг 10.4 сая, бусдаар гүйцэтгүүлсэн бусад бараа ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг-68.6, Засаг даргын хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг-116.6, Засаг даргын нөөц хөрөнгийг-74.2 сая, Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг-39.2 сая, нийт 320.9 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийг шалгахад 6 байгууллагаас 33.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.3, 20.4 дахь заалтад заасан мэдээллийг ил тод мэдээлээгүй тул зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн.
2. Баянтал сумын Засаг даргын тамгын газар нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.1.2, 15.2.6 дахь заалтыг зөрчиж орон тоо, төсөв батлагдаагүй байхад 3 албан хаагчид ажил хавсарсны нэмэгдэл 5.6 мянган төгрөгийг олгосон тул зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн.
3. Баянтал сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.1.3-т заасныг зөрчиж 15 төлөөлөгчдөд 0.8 мянган төгрөгийн урамшуулал олгосон тул буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоосон.
4. Баянтал сумын ОНХС-гаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.1.7-т заасныг зөрчиж 0.04 сая төгрөгийн согтууруулах ундаа худалдан авсан.

5. Говьсүмбэр аймгийн Санхүүгийн хяналт дотоод аудитын алба нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-т заасныг зөрчиж 1.3 сая төгрөгийн бичиг хэргийн материалыг шаардлагагүйгээр нөөцөлсөн.
6. Говьсүмбэр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т заасныг зөрчин Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчийн үйл ажиллагааны зардлаас МУЗЗНДНТУТХуульд заасан чиг үүрэгт хамааралгүй арга хэмжээнд 25.5 сая төгрөг зарцуулсан тул алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн байна.

4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 147 мэдээллээс 139 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийн хугацаа болоогүй, 6 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Аймгийн ТЕЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар харьяа 17 байгууллагад Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 3,364.9 сая төгрөгийн зөрчил илэрч, 16 байгууллагад 3,278.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах 14 албан шаардлага, хариуцлага тооцуулах 2 албан шаардлага өгч, 1 байгууллагад 86.6 сая төгрөгийн 1 зөвлөмж өгсөн байна.

4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Татварын тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой тулган баталгаажуулалтаар ТЕЗ-ийн харьяа 18 байгууллага цахим төлбөрийн системд тулгалт хийгээгүйгээс төлбөрийн баримтаар ажил гүйлгээ баталгаажаагүй 533.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч 37.6 сая төгрөгийн 3 алдааг аудитын явцад залруулан, 23.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмж, 472.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай болон татварын тухай хууль тогтоомжийн хэрэгжилттэй нийцээгүй гэж дүгнэлээ.

4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.7.1 Завсрын аудитын хийгээгүй.

4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн талаар бичнэ.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	2	75.8	2	75.8	100
Зөвлөмж	1	-	0	-	0
Нийт дүн	3	75.8	2	75.8	66.6

/сая төгрөгөөр/

Өмнөх аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байсан тул зөвлөмж өгсөн бөгөөд тайлант онд дээрх алдаа зөрчил давтагдсан, зөрчлийн дүн нэмэгдсэн тул зөрчлийг арилгах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудад илэрсэн алдаа зөрчил:

Аймгийн ТЕЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 14 төсвийн байгууллага, 5 ОНӨААТҮГ, 9 тусгай сан, 3 төсвийн төвлөрүүлэн захирагч нийт 31 тайлан нэгтгэгдсэнээс 14 байгууллагад дүгнэлт гаргаж, 17 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” 9, хязгаарлалттай 4 /Баянтал сумын ЗДТГ/, /Баянтал сумын төвлөрүүлэн захирагч/, /Баянтал сумын ЗДТГ/, /Шивээговь сумын төвлөрүүлэн захирагч/, Татгалзсан 1 /Цөм сүргийн үржлийн төв ОНӨҮГ/ санал дүгнэлт/ тус тус өгчээ.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 11,741.0 сая төгрөгийн 159 алдаа зөрчил илрүүлэн, 57.2% буюу 6,725.2 сая төгрөгийн 57 алдааг аудитын явцад залруулж, 35.8% буюу 4,205.8 сая төгрөгийн 40 зөрчлийг арилгах албан шаардлага, 0.2% буюу 11.9 сая төгрөгийн 16 төлбөрийн акт тогтоож, 6.8% буюу 798.1 сая төгрөгийн 44 зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн байна. Үүнээс: Нийцлийн аудиттай холбоотой зөрчил 3,887.8 сая буюу 33.1%-ийг эзэлж байна.

Өмнөх аудитаар нийт 7,275.4 сая төгрөгийн 323 алдаа, зөрчил илрүүлснээс 2,624.8 сая /36.1%/ төгрөгийн 130 алдааг аудитын явцад залруулж, 29.4 сая /0.4%/ төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2,915.3 сая /40.1%/төгрөгийн 89 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 1,705.9 сая /23.4%/ төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 81 зөвлөмж өгсөн байна.

Харьяа байгууллагад илэрсэн алдаа зөрчлийг өмнөх онтой харьцуулбал:

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Тайлант он		Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал		Зөрүү	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Залруулга	130	2,624.80	57	6,725.20			-73	4,100.40
Залруулаагүй алдаа	0	0	0	0			0	0.00
Төлбөрийн акт	23	29.4	16	11.9	2	0.8	-7	-17.50
Албан шаардлага	89	2,915.30	40	4,205.80	28	3,777.70	-49	1,290.50
Зөвлөмж	81	1,705.90	44	798.10	11	110.1	-37	-907.80
Нийт	323	7275.4	157	11,741.00	41.00	3,888.60	-166.00	4,465.60

(Эх сурвалж: ТАБ-ын статистик мэдээ)

4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал илрээгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ-НЭГТГЭСЭН ТАЙЛАНТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

Аудитаар нийт 5.0 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 5.0 сая төгрөгийн алдааг залруулсан. Үүнд

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт данснаас "Сүмбэр гарден соёл спорт амралтын хүрээлэнгийн засварын ажлын зураг төсөв хийлгэх ажил"-н урьдчилгаа 5.0 сая төгрөгийг "Ориентплюс" ХХК-д шилжүүлсэн боловч шууд зардлаар тайлагнасан.

5.1 Төлбөрийн акт тогтоогоогүй.

5.2 Албан шаардлага

1. Аймгийн ТЕЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар харьяа 17 байгууллагад Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 3,364.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн бөгөөд өмнөх аудитаар өгсөн зөрчил бууруулах зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тогтоох, албан шаардлага өгөх журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.10-т заасныг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Цөм сүрэг үржлийн төв нь Төсвийн тухай хуулийн 8.9.8 заалтыг зөрчиж, 2022 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд аудит хийлгээгүй, тайланг хуулийн хугацаанд гаргаж ирүүлээгүй, татгалзсан дүгнэлт авсан тул удирдлагад хариуцлага тооцох

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөөг 21.1 сая төгрөгөөр биелүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,